

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244815

**ПРОФЕССОР М.БАЗАРРАГЧААГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ГАРАЛ
СУДЛАЛ, ТҮҮХЭН БҮТЭЭВЭР СУДЛАЛЫН БҮТЭЭЛҮҮДИЙН ТУХАЙ
(ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШҮҮМЖ)**

М.Ууганбаяр

Профессор М.Базаррагчаа багш Монгол үгийн гарлыг мөшгөх нь I-II 1992, Монгол үгийн гарлыг мөшгөх нь III-V, 1994, Монгол үгийн гарлыг мөшгөх нь VII 2020, Ажнай 1996, Монгол хэлний авиа сэлгэх ёс 1987, Эртний монгол хэлний үгийн бүтэц, түүний зарим онцлог 2005 зэрэг бүтээлдээ монгол хэлний үгийн гарлыг судалж, үнэн хэрэгтээ монгол судлалд шинэ үеийг эхлүүлсэн юм. Профессор М.Базаррагчаа багшийн монгол хэлний гарал судлалын бүтээлүүд жин, нөлөө, ач холбогдлоороо монгол хэлний гарал судлал түүхэн бүтээвэр судлалын салбарт хэвлэгдсэн урьдах бүтээлүүдийг давж илүүрхэж чадсан, хамгийн өргөн хүрээг хамарсан хийгээд эртний монгол хэлний дотоод бүтцийн онцлогийг гаргахдаа Г.И.Рамстедт 1935, 1949, 1952; Н.Поппе 1960; Б.Я.Владимирцов 1929; Б.Ринчен 1966; Ш.Цэцэнцогт 1988 тэргүүтэн урьдах эрдэмтдийн судалгаанаас ихээхэн өөр буюу утгаа анх удаа монгол хэлний бүтээврийг тодруулан авч үзсэн нэн шинэ, чанарын өөр түвшний судалгаа билээ

Монгол хэлний гарал судлал юуны өмнө түүхэн бүтээвэр судлалтай холбоотой бөгөөд. (Базаррагчаа 1997:3) гарал судлал түүхэн бүтээвэр судлалын үндсэн хандлага болох ажээ.

Профессор М.Базаррагчаа багш монгол үгийн гарлыг авиа утгын харилцан нөлөөллөөр, түүхэн үүднээс үгийн бүтээврийн хэлбэр агуулгын бүтцийг авч үзэхдээ авиаалбар сэлгэх утгалбар салаалах хоёрын шүтэлцээг анхаарчээ. Хэлний хэлбэр агуулгыг хамрах үе-утгалбар (силла-семема) нь түүхэн бүтээвэр судлалын хамгийн бага нэгж ажээ. Үелбэр утгалбарын өөрчлөлт нь авиаалбар сэлгэх утгалбар салаалахтай нягт холбоотой юм. Монгол хэлний идэвхгүй язгуур хэмээн нэрлэсээр ирсэн утгат хэсгийг цуваа цагийн үүднээс задлан монгол хэлний нөхөцмөл язгуур үндсийг тодруулах гэхдээ дан ганц авиаалбар үелбэрээр хэсэглэх төдий бус тэдгээрийн анхны гарвал болон шилжмэл утгын холбоог авиа сэлгэх ёстой холбон сэргээх хэрэгтэй ба түүхэн бүтээвэр судлал авианы утга, түүнээс шууд хамаарах авианы улмаар үе бүтээврийн утгатай холбогдох бөгөөд монгол үгийн гарлыг тайлбарлахад авианы болон үеийн утгаас бүтээврийн утга,

түүнээс үгийн бүтцэд шилжүүлэн шатлах байдлаар судлах, гарал зүй нь түүхэн үүднээс тухайн үгийн бүтээврийн хэлбэр агуулгын бүтцийг судалж анхны бүтээврийг харьцуулан байж сэргээх ёстой ажээ.

Профессор М.Базаррагчаа эртний монгол хэлний үг бүтэх ёсыг тодруулан бичсэнээс (Базаррагчаа 2020: 129-141) доор товчхон авч үзье

Үе-утгалбар ганцжих ёс гэдэгт, (CV) CV гэсэн дан ганц үе-утгалбар нь бие даасан цөөвтөр үгс ба дагавар нөхцөл бүтээх ба С ба V -ээр бүтсэн дагавар нөхцөл бүтээжээ. Үүнийг үе-утгалбар ганцжих гэж болох ба ийнхүү хамгийн бага нэгж үүссэн нь хийсвэрлэн сэтгэх, нөгөө талаас хэлний хэмнэх ёстой холбогдоно. Жишээ нь: Бие Ганц тоо Олон тоо 1 bi ba 2 ċi~(tia) ti 3 i a болно. Гуравдугаар биеийн “i, a” нь хоёрдугаар биеийн төлөөний үгийн “ta, ċi” үе-утгалбарын гийгүүлэгч гээгдсэнээс үүдэж, хоёрдугаар биеийн төлөөний үгсийн “алслах, талийх, холдох” гэсэн утгаас бүр “ алсалж” гуравдугаар биеийн төлөөний үгсийн ганц олон тоот хэлбэр буюу эгшиг-утгалбар бий болжээ. Үүнд: “ta” нь taliyi (талийх), tala (тал газар), tala (алах, талах), tani (таних) зэргийн “ta”-гаас, “ċi” нь ċiliyi- (чилийх), ċile (чилэх), ċinege (чинээ, хэр хэмжээ) зэргийн “ċi”- гээс тус тус үүсжээ. Биеийн төлөөний үгсийн ганц олон тоог анх “a~i”-гийн сэлгэцээр ялгаж байсан боловч яваандаа тэрхүү ялгаа арилж, “ba” нь “ta” болж, улмаар “na” болсон боловч энэхүү “a” үе-утгалбар нь na - ma - yi (намайг), nada-dur (надад), ċimā-yi (чамайг), ċimā-tā-i (чамтай) гэх мэтээр ганц тоог илтгэх болсны дээр үндэс бүтээх “n” нь “m”-тэй сэлгэж түүний хойно оршихын тийн ялгалын “-a” нөхцөл залган na - mayi, ċimā-yi гэх болжээ. Энэ нь “-a” болон “da” нөхцөл нь “n – m” үндэстэй зууралдаж, үндэс бүтээх болсон тул нөхцөлийн үүрэггүй болжээ. Иймээс хойноо “-yi, tai, dur, bār, luṗā” зэрэг харьяалахаас бусад тийн ялгалын нөхцөлийг үндэс бүтээх болсон “-a, da” нөхцөлийн дараа залгах болсон байна. “ba~ba” нь “орших, овоорох” утгатай “bāyi- (байх), baṗū- (буух), ba-ṗān (баан), bö-gē-n (бөөн), ba-ṗa-si (бааш), ba-ṗa- (баах) зэрэг үгийн “ba” үе-утгалбараас; “холдох, алсрах” гэсэн утгатай хоёрдугаар биеийн ta-li-yi- (талийх), ta-la (тал), ċi-li-yi- (чилийх), ċi-le- (чилэх) зэрэг үгийн “ta, ċi” үе-утгалбараас тус тус үүсжээ. Харин гуравдугаар биеийн ганц олон тоот “i, a” нь хоёрдугаар биеийн төлөөний үгийн эхний “t~ċi” гийгүүлэгч гээгдэн, үе- утгалбар задгайрснаас үүсжээ. Зөвшөөрөх санаа бүхий ja (за), je (зээ), өвдөх зовох санааг илэрхийлэх “yo” (ёо ёо) гэх мэт өгүүлбэр, зэрэгцүүлэн онцлох утгат “ċu” (ч), ялган онцлох утгат “la” (л) хэмээх баймжит бүтээвэр нь jabsar (завсар), jaba (зав), jöb (зөв), jö-b-si- (зөвших), dung ki (дун хийх), dungsi- (дунших-жирэмсэн хүний зөөлөн зөөлнөөр өвдөх), ċu-ṗ (цуг), e1e (эл, энэ) зэрэг үгийн тэргүүн үе- утгалбараас гаралтай юм. Тухайлбал dang ki (дан хийх), danggi (ханги данги), dongsi- (донших хэсүүчлэх, дон дон нурших), dongṗud-, dongṗs- (элдвээр чалчих), dungsi (байн байн өвдөх), dung ki- (дун хийх), dünggine- (үргэлжийн нүргэлэх), dünggina- (мунгинах, загнах), denggine- (сэнгэнэх дэнгэнэх), dengsel- (дэнсэл), dongsul- (доргих), düngsüyi- (эл хуль болох) гэх зэргээр авиа дуурайх үгсийн “da...” үе - утгалбар нь “ja” улмаар “ya” болон сэлгэх ба “yo” хэмээх мэдрэхүйн өгүүлбэр нь бие эрхтэн дотроосоо “dung dung, dong dong” гэж сэргэдэн “өвдөх” гэсэн үйлдлээс үүсжээ.

Энэхүү “yo yo” нь “ya ya, ye ye” зэрэг мэдрэхүйн өгүүлбэртэй гарал нэг болно. Үүнээс хүүхдийн дооглох уе̄ уе̄ bö bö (еэ еэ бөө бөө) ганцажсан өгүүлбэр бий болжээ. Мөн өнгөрөн төгссөн цагийн “-ba, bāi” нөхцөл нь дээрх “ba’ толгойт үгсээс үүсэлтэй бөгөөд энэ нь “тодорхой биеийн орших утгаас цагийн утгад» шилжсэн болно. Энэхүү “ba-” үе-утгалбар нь арын эгшгээ гээж, үе-утгалбар задран “b” гэсэн гийгүүлэгч-утгалбар болж “sed-(ü)-b (сэдэв), töс-(ü)-b (төсөв), e-b (эв), qa-b (хав) зэрэг бүтээсэн ба “-ra, la, ma...” үе-утгалбарын гийгүүлэгч эгшиг хоёрын завсар шурган ордог. Жишээ нь: yurāyi- (гурайх), dörgüi- (дөрийх), sarāyi- (сарайх), tabi- (тавих) зэргээс yurbāyi- (гурвайх), yurban (гурав), dörbüyi- (дөрвийх), dörben (дөрвөн), sarbāyi- (сарвайх), Ø~ arban (арав), talbi- (талбих) зэрэг 132 үүсэхээс гадна i-li- (илэх)-ээс i-l-bi- (илбэх), nila- (нялах)-аас nil-bu- (нялбах), cö-le (цөлөх)-өөс cö-l-be- (цөлбөх), ju-lu/a- (зулах)-аас ju-l-bu- (зулбах) jo-li- (золих)-оос jo-l-bi- (золбих, золбирох), quni- (хумих)-аас qumbi- (хумбих), süle- (сүлэх) -ээс sülbee (сүлбэх) to-mi-la- (томилох), kele- (хэлэх)-ээс kelbe- (хэлбэх) qola (хол)-оос qolba- (холбох), sülbe- (сүлбэх)-ээс sübe (сүв), salba- (салбах)-аас saba- (савах) зэрэг үг үүсжээ. Энэ шургасан “b” гэх гийгүүлэгч-утгалбар нь “бөөгнөрөх, томрох” буюу уг үйлийн явцыг ихэсгэх эрчимжүүлэх утгыг илтгэж байна. Гэтэл зарим үгнээ шургасан “b” нь үлдэж, өмнөх “l” гийгүүлэгч- утгалбар гээгдэх нь хааяа тохиолдоно.

Үе утгалбар нийлэх ёс гэдэгт, үе-утгалбар хоршихын хувьд, үе-утгалбар харилцан зэрэгцэн хоршиж, монгол хэлний язгуурын гол махбодыг бүтээдэг. Жишээ нь, “бөөгнөрөх, хурах” гэсэн утгатай “qa-” гэсэн үе- утгалбар “шигэх нягтрах” гэсэн утгатай “si” үе - утгалбартай хоршвол “qa-si” (хаших), qa-sir (хашир-туршлага хуримтлах), qa-si-ra- (хашрах, туршлагаас хашир суух), qa-šing (хашин-цөв шаар болсон тос, хойрго, элэгдсэн зүйл), qa-si (хаш- хонин хашаа), qas (хаш/хас чулуу) зэрэг үгс үүснэ. Энэ “qa” нь “ya”-тай сэлгэвэл ya-sil- (гашлах), ya-si-yü (гашуу оргих), ya-si-yü ya-si-yün (гашуун гушуун), “ba”-тай сэлгэвэл “ba-si- (баших), ba-si-r (башир), ba/i-si-la-γ (бяслаг) зэрэг үгс бүтэж, “si” нь “sa”-тай сэлгэвэл, ya-sa-l (гаслах), ba-sa-r (басар-тай) asa-r ba-sa-r (асар басар нохой) хэмээх үг үүсжээ. qa үе - утгалбарын “a” нь “o”-той сэлгэвэл qosi- (хоших, холих), qo-si-la-ng (хошлон), qosi-ya (хошоо хос), qo-sü-i (хошой), qošu-ng (хошин) хэмээх үгс бий болжээ. Жишээ нь: ta-ba (тав дух) ~ ba-tu (бат бэх), ba~ya: ta-γā (тааламж), ya-tu-l- (гатлах), ta-yü-l- (туулах), ta-bu-n (тав)~bu-ta (бургас), ü~e~i: bü-tü- (үйлс бүтэх), bü-te- (бүтэж үхэх), bi-tü-gü-n (битүүний өглөө), bu-ča- (буцах); bu-ča-l (буцлах), bi-ča- (бяц гишгэх), ma-ču- (мацах), ni-ča (хөх няц), ni-ču- (няцах), ni-čü-gü-n (нүцгэн), no-ču- (гал ноцох, нохой ноцох), mō-če (арван таван минут), mō-či-г (мөчир), mō-či (мөч мөчөөр нь салгах, мөчих), mō-če-l-ge (мөчлөг -арван хоёр жил, сорилго), bü-če (bü-či (оосор), bü-či (бүслэх, бүрхэх) гэх мэтээр “уг юм задрах, хэсэг болох, эргэх хөрвөх” гэсэн утгат үгс нь үе-утгалбар хоршихоос гадна авиалбар сэлгэж бүтжээ.

Үе-утгалбар давтахын хувьд, үе-утгалбар зэрэгцэх, алгасах замаар давтаж, язгуурын гол цөмийг бүтээдэг. Жишээ нь ta-ta- (татах), či-či- (чичих), čo-či- (цочих, сочих), či-ča (чац), či-ča-yü (чацуу), či-ča-r-qā-i- (чацархай-мал гөрөөсний

өөхтэй нарийн гэдэс), *ᠰu-ᠰa-* (цуцах), *ᠰu-ᠰa-l/i-* (цуцлах, тайлах задлах), *ᠰe-ᠰe-n* (цэцэн), *ᠰa-ᠰa-* (хах цацах), *ᠰa-ᠰu-* (тархаан цацах), *ᠰa-ᠰu-γ* (цацаг), *ᠰi-ᠰa-γa* (амьтны шингэн баас) гэж зэрэгцэн давтах ба алгасан давтах нь: *ta-n-ta-yi-* (тантайх- бүдүүн махлаг болох), *to-ntu-yi-* (тонтойх), *tu-n-ta-yi-* (тунтайх), *te-n-te-yi-* (тэнтийх), *tü-n-tü-yi-* (түнтйх), *qa-b-qa-yi-* (хавхайх), *qa-b-qa* (хавх), *qo-b-qu* (ховх өшиглөх), *qa-m-qa* (хамх), *ke-m-ke* (хэмх), *qa-m-qa-yi-* (хамхайх), *ke-m-ke-yi-* (хэмхийх), *sa-r-sa-yi-* (сарсайх), *se-r-se-yi-* (сэрсийх), *so-r-su-yi-* (сорсойх), *sö-rsü-yi-* (сөрсийх), *ᠰa-lᠰᠠ-yi-* (цалцайх), *ᠰu-l-ᠰü-yu-* (цулцайх), *ᠰe-lᠰe-yi-* (цэлцийх), *ᠰe-m-ᠰe-yi-* (цэмцийх), *ᠰo-m-ᠰü-yi-* (цомцойх), *ᠰö-m-ᠰü-yi-* (цөмцийх), *ᠰo-γ-ᠰü-yi-* (цогцойх), *ᠰö-g-ᠰü-yi-* (цөгцийх), *ᠰo-γ-ᠰa* (цогц), *ᠰe-g-ᠰe* (цэгц), *ba-l-ba-yi-* (балбайх), *ba-l-ba-* (балбах) гэж алгасан давтаж байна.

Үе-утгалбар хөрвөх тухайд, үе-утгалбар нь нэр ба үйл үг болох салаална. Жишээ нь: *ta-γaᠡ* (таа) ~ *ta-γā-* (тав, тааламж, таах) гэхэд *ta-γā-* (таах) гэвэл тусах үйл үг болон салаалж, хөрвөл болсон байна. *to-γā* (тоо тоолох) ~ *to-γū* (тоох тоомсор) *ta-la* (тал хэсэг) ~ *ta-la-* (талах, тонох, алах) *bu-qa* (бух) ~ *bu-qa-* (бухах, булгих) *bü-ri-(n)* бүр, бүрэн ~ *bü-ri-*(бүрэх, хучих) *bü-r-ke* (бүрх малгай) ~ *bü-r-kü-* (бүрхэх) *jū-i* (эв зүй) ~ *jūeyi-*(зүйх, эвлүүлэх).

Үе-утгалбар задгайрах тухайд, үгийн эхний үе -утгалбарын эхний гийгүүлэгч гээгдэх нь зөвхөн “*p*-f-x-h-Ø*” байх бус, бусад гийгүүлэгч байснаа гээгдэж үе-утгалбар задгайрчээ. Монгол хэлний эгшгээр эхэлсэн үгс нь эхэндээ сэлгэмэл гийгүүлэгч байсан ажээ. Жишээ нь, *a-b* (авах), *a-m* (амах) гэсэн үг нь “уг юмыг өөрийн болгох, уг юмыг нөгөөгөөс нь салгах” гэсэн утгатай ба *a-ba-li* (авааль), *abura-* (аврах), *aba-d* (авд-авсаар) гэх зэрэг үг бүтжээ. Үүнийг Г.И.Рамстедтийн манж хэлнээ *afu* (авах), түрэг хэлнээ *awu-ᠰ* (атга), кобайл хэлнээ *omas* (*aw-maz-nэхэх*, сүлжих, залгах) гэж харьцуулсан хийгээд, Э.В.Севортяны авч үзсэн түрэг хэлний *ab/a* (аван), *av* (хаших, хүрээлэх) зэрэг үгтэй *ab* (авах) хэмээх үйл үг нь холбогдох ажээ. Тухайлбал, *ab* (авах) хэмээх үйл үг нь эхэндээ сэлгэмэл “*q~s*” гийгүүлэгчтэй байсныг *qab eb* (хав эв), *ebke* (эвхэх), *qaba-* (хавах, хавсрах), *qabqa* (хавах), *qabsi-* (хавших), *qabsur* (хавсрах), *qabᠰi-* (хавчих), *qamki-* (хамжих), *qabqaγ* (хавхаг), *ebse-* (эвсэх), *sabqa* (савх) ~ *qabsa* (хавсах), *saba* (сав), *sabsalγ-a* (савсалга-хавчуур мод) зэрэг үгээс гаргаж болох бөгөөд эдгээр үгс нь “хоёр юм нийлэх” гэсэн утгаараа “гаднын юмыг өөртөө нийцүүлэх буюу авах” гэсэн утгатай нэг адил байгааг ажиглаж болох аж. *a.qaba-* (хавах, хавсрах), *eb qab* (эв хав), *qabqa*(хавх), *ebke-* (эвхэх), *b.saba-* (савах, салгах), *saba* (агуулах хэрэгсэл), *ab sab* (хэсэг бусад), *sabqa* (савх) гэж харьцуулбал “хоёр юм нийлэх салах” үйлдэл нь “дотроо гаднах юмыг агуулан авах” гэсэн утгаас *a-b-* (авах), *a-m-* (амах) (өөрийн болгох) хэмээх үг үүсэж, *q~s* “гийгүүлэгчид өөр хоорондоо сэлгэн, сул байранд орж, цаашид гээгджээ. Жишээ нь: *e-ᠰe-*(эцэх) ~ *ᠰu-ᠰa-* (цуцах), *e-ü-ke* (үүх) *te-ü-ke* (түүх), *ü-kü-* (үхэх) ~ *bökü-* (бөхөх), *ö-bü-r* (өвөр тал) ~ *qo-bu-r* (ховор живэр), *a-γa-ra-* (аарах) ~ *ba-γa-ra* (баарах), *idee* (идэх) ~ *ki-da-* (хядах), *u-du-m* (удам судар) ~ *qu-da* (худ ураг)~ *qu-da-l-du-* (худалдах), *ü-jü-gü-r* (үзүүр озоор)~*ki-ja-jāg* (хязгаар, зах хил), *i-ja-γü-r* (язгуур) ~ *qa-ja-jā-r* (хазаар)~*qa-ja-* (хазах); *i-be-gē* (ивээх) ~ *i-be-* (ивэх, хавчуулах) > *sibe-* (шивэх шавах), *a-la-*

(алах) ~ ta-la- (алах талах), i-γ-ца (ягц)>ni-γ-ta (нягт)~ noγ-tu (ногт), a-na- (анах, отох) > q~sa- на (ханах, хатгах, санах сэдэх), a-ki-(ахих) > da-ki- (дахих), e-ke (эх) > ja-qa (эх зах), e-l-gü- (өлгөх)~ se-l-gü- (сэлгэх), ö-či- (өчих) mō-če-gē (мөчөө), ma-ču- (мацах) bu-ča (буцах); u-l/a-ba-γā (улбаа) > qo-l-bu-γā (холбоо)~ sülbegē (сүлбээ)~ qo-l-bu- (холбох), sū-l-be (сүлбэх) > sū-l-e- (сүлэх), sū-l-ji- (сүлжих); a-mi-ya (амиа), e-mi-ye(эмээ-); o-nu- (онох) > qo-nu- (хонох), a-ni-r (анир чимээ) > ta-ni-r (анир танир) ü-nür (үнэр), ta-nu-r (танар) e-bü-r (өвөр)~ö-bür (өвөр), e-be-r (эвэр), ebe-re- (эврэх) se-be-re- (сэврэх), se-me-re- (сэмрэх), o-bu-r (овор) > qo-bu-r (ховор), e-mü-ne (өмнө), e-be-d- (өвдөх), e-be-de- (эвдэх), e-m-ne-g (эмгэг), e-mje-g (эмзэг), e-m-ne-g (эмнэг); a-mi (амь амьсгал) > ta-mi-r (тамир), üi- (цай үйх)>jü-yi- (зүйх эвлүүлэх); jö-gē- (зөөх) jo-γū- (зоох); sū-l-ji- (сүлжих), sū-l-je (сүлз-утасны ороомог), sū-l-be- (сүлбэх) ~ qo-l-bu- (холбох) e-gū-s- (үүсэх) > te-gū-s- (төгсгөх); u-ru-γu (уруу)> bu-ru-γu (буруу), bu-ra- (бурах); gi-s-ki- (гишгэх, алхах. хөлөөр дарах, азарга гишгэх) < i-s-gi- (гишгэх, алхах) ~i-s-kü-l (өшиглөх), e-si (иш) > ge-si-gü(n) (гишүүн); a-ča- (өлгөх тээглүүлэх) > γa-ča- (гацах); Эдгээр жишээнээс үзвэл, үгийн тэргүүн үе-утгалбар (CV)-ын эхний t~d, č~j b~m, γ~q~s, n гийгүүлэгч гээгджээ. Иймээс эртний монгол хэлний үгийн эхэнд зөвхөн “p~f~x~h~Ø” гийгүүлэгч байсангүй “r”-ээс бусад гийгүүлэгч үгийн эхэнд байснаа гээгдэж үг бүтээсэн болох нь тодорхой байгаа ажээ.

Үе- утгалбар задрахын тухайд, үе-утгалбарын ”a, i, u, e, I, ü” эгшиг сул байранд орсноос гээгдэж, “b, γ/g, r, s, d болон “m, n, mh, l” гэсэн есөн гийгүүлэгч үе төгсгөх буюу дэвсгэрлэх ёс үүссэн нь хэлэхийн цуваанд гийгүүлэгчийн нийлц буюу хоршцыг бий болгожээ. Нөгөө талаар “VC, CVC” гэсэн үелбэрийг бүтээсэн явц нь ebü- (ebür, ebüce-, emüne, ebčigün) eb~em (eber, ebed-, ebedčn. ebde-, emgeg, emgem-, embüre-, emtere-, emteger) (Н Поппе 1954) ge- (гэх), a- (байх), a-ма (ам), ba-γ (баг), u-γ (уг), qo-li- (холих) зэргээс эртний монгол хэлнээ CV, V гэсэн язгуур (Чой.Лувсанжав 1971) ö-ng-ge (өнгө), ö-ng-ge-yi- (өнгийх), ö-ng-ge-re- (өнгөрөх),önggür (өнгөр); jori- (зорих), jo-či-la- (зочилох), jo-l-γa- (золгох) зэргийн анхдагч язгуур нь “ö-, jo-” (Ш.Лувсанвандан 1963) гэх мэтээр үзсээр иржээ. Эртний монгол хэлнээ зөвхөн “CV” гэсэн бүтэц бүхий үе-утгалбар нь үгийн эхэн, дунд, адагт тохиолдож байжээ. Үүний эхний гийгүүлэгч нь гээгдвэл түүнийг үе-утгалбар задгайрах ёс, үгийн дунд адагт эгшиг нь гээгдвэл түүнийг үе-утгалбар задрах ёс гэнэ. 1. qa-da- (хадах), a-da- (адах) < qa-d-qu-(хатгах), a-d-qu (атгах), a-d-qa-γ (атгаг сэжиг), qu-da- (худах) < qud-qu- (хутгах), u-da- (удах) < u-d-qu-хутгах), u-ča-ra- (учрах) < u-či-r; o-nu- (онох), o-n (он жил); a-na- (анах отох) < a-ng (ан ав); bögēčeyi- (бөгцийх, бээцийх) 2.а. -ma-γā 2.б. -da 2.в. -la<l, γurba-γū-la (гурвуул)~baγa-čū-l (багачуул) 2.г. tursi-γül-či (туршуулч), damna-γür-γa (дамнуурга), torγa-γüli (торгууль) < qaru-γül (харуул, харуулч), daγa-γüli (дагуул) 2.д. -la >l-, čaγ-la- (цаглах), köngge-(n)-le- (хөнгөлөх), ürgülji-le- (үргэлжлэх); čakila- (цахилах) ebde-le- (эвдлэх);

Үе- утгалбар тонгорохын тухайд, хоршин орсон үе утгалбар нь байраа солин тонгорч болно. Та-γū-l- (туулах) гэдэг үгийн тэргүүн ба дэд үе - утгалбарыг байраар нь сольж тонгоруулбал γatu-l- (гатлах) гэсэн үг бүтнэ. Энэ хоёр үг

хөндлөөшөө орон зайн доторх саад бэрхшээлийг давах гэсэн утгаараа ойролцоо аж. Бас *getü-l-* (гэтлэх) гэсэн хувилбар үгийг дээрхийн адил байраар нь тонгоруулбал *te-gü-l* (төгөл) буюу *te-gü-l-de-r* (төгөлдөр) хэмээх үг бий болсон нь “туулан гарах” гэсэн утгаараа *γatul*, *getül* гэсэн үгийн утгатай ойролцоо байна. Дээрх үгийн “-l” гийгүүлэгч “-s”- тэй сэлгэж, *te-gü-s* (төгс төгөлдөр) буюу *te-gü-s-* (төгсөх) хэмээх үг бүтэх ба “ta-” гэсэн тэргүүн үе - утгалбар нь “da-”-тай сэлгэж, *dayūs* (дуусах) хэмээх үг салаалжээ. Түүнчлэн *qo-tū-yi-* (хотойх) гэсэн дүрслэх үйл үгийн тэргүүн ба дэд үе-утгалбар нь байраа сэлгэн сольж, *to-qū-i* (тохой) хэмээх нэр үг үүсжээ. Г.Д.Санжеев *si-tü-* (шүтэх) ~ *tü-si-* (түших), *qa-si-* (хаших) ~ *si-qa-* (шахах) (Г.Д.Санжеев, 1953) жишээг иш татжээ Жишээ нь: *qa-b-ṣi-* (хавчих), *qa-b-ṣi* (хавч), *qa-b-ṣi-yi-* (хавчийх) хэмээх үг нь *ṣib-qa* (чавх) хэмээх үг үүссэн нь “-b-” гийгүүлэгч-утгалбарыг алгасан тонгорсон байна. Энэ хоёр үг нь “хөвчрөх, чангарах” гэсэн ерөнхий утгаараа ижил байна. Энэхүү үгсийн “ṣi-” үе-утгалбар нь “ti-” буюу “ta-” үе-утгалбараас гаралтай учраас *qa-b-ta-yi-* (хавтайх) гэдгээс *ta-b-qa-yi-* (тавхайх), *ta-b-qa-yi* (тавхай) хэмээх үтс бий болжээ. Энэ хоёр үг нь “өргөөшөө тархах” гэсэн утгатай юм (Базаррагчаа 1992, 15-18, М. Базаррагчаа 1995. 287-305) Жишээ нь: *ji-ru-m* (журам) гэсэн үгийн тэргүүн ба дэд үе- утгалбар байраараа тонгорч, *pe-ji-m* (журам) гэсэн үг үүсгэж орос, франц зэрэг хэлнээ тархжээ. Жишээ нь: *γa-da-na* (гадна)~ *daya-* (дагах), *dā-γa* (даага); *nökür* (нөхөр)~ *kö-nü-* (хөнөөх, сөнөх), *kö-nü-gē* (хөнөөх); *qu-ṣa-* (хуцах) ~ *ṣi-qu-l-da-* (цухалдах), *ṣuquyi-* (цухуйх); *si-ba-* (шавах)~ *ba-si-* (баших), *qa-si-* (хаших)~*si-qa-* (шахах), *qo-ṣu-ng* (хошон)~ *ṣo-γ* (шог); *qo-si-γü* (хошуу) ~*ṣu-qay-i-* (шухайх); *sarbayi-* (сарвайх)~ *barsayi-* (барсайх); *ṣelmeyi-* (цэлмийх)~ *melṣeyi-* (мэлцийх); *miltayi-* (мялтайх)~ *talmayi-* (талмийх), *talimiayira-* (талимаарах), *tar-mi-yi-* (тармийх); *sarmayi-* (сармайх)~ *marsayi-* (марсайх); *tegēre-* (тээрэх тойрох), *tegērem* (тээрэм)~ *te-r-ge* (тэрэг); *tergel* (тэргэл) гэх мэт үг бүтнэ.

Үе-утгалбар нэвчихийн тухайд үгийн дунд хоёр эгшгийн дунд орсон “γ/g” гийгүүлэгч нь өмнөх ба хойнох эгшигт нэмэлт өргөлт оногдсоноос болж гээгдэн, үе-утгалбар нийлэн нэвчиж, монгол хэлнээ урт, хос эгшиг үүсжээ. Энэ бол авианы хувьсал болох ба бүтээвэр зүйн үүднээс бол, хоёр бүтээвэр нийлж, нэг бүтээвэр мэт болдог байна. Жишээ нь: *ta-γa-* (таах- мэдэхгүй зүйлдээ оюун ухаанаа бэлчээж уг юмыг танихын тулд тэр юманд тааруулан барагцаалах) хэмээх үгийн дэд утгалбар нь “онцлох” утгатай учраас өөртөө буюу тодруулбал “a” эгшигтээ нэмэлт өргөлт авч улмаар уртаар хэлэгдэх болж, өмнөх “γ/g” гийгүүлэгчийг сугарахад хүргэдэг ажээ. Ингэж монгол хэлнээ урт эгшиг буюу нэвчмэл бүтээвэр бий болжээ. Энэ үгийн “t” нь хөцдлөөшөө өргөсөн холдож алслах, “a” нь “уужимхан тархах, эрч үүсгэх” гэсэн утгатай нь *ta-γa-* (таах), *ta-γā-* (таатай), *ta-γā- ga-* (таарах), *ta-γā-may* (таамаг), *ta-γā-la-* (таалах), *ta-γā-bu-ri* (таавар) зэрэг үг бүтэх эх суурь болжээ. Гэтэл сугардаг гийгүүлэгчийн арын “a” эгшиг нь “i” эгшгээр сэлгэвэл нэмэлт өргөлт нь өмнөх үе-утгалбарын эгшигт шилжиж, “γ”- ээс “y” болон сэлгэсэн гийгүүлэгч сугарснаас хос эгшиг буюу нэвчмэл бүтээвэр үүссэн байна. Үүнд: дээрх *taγā-* (таах). *ta-γā* (таа), *tāyi-* (тайх-тахих) хэмээх үг салаалсан тул *tāyil-*(тайлах- таах бус, уг юмны учрыг тайлж

задлан ойлгох, дээлээ тайлах), *tāyid-* (тайтгарах- таатай -тавтай болох), *tayilγa* (тайлга- онгон шүтээний тахилга), *tāyilburi* (тайлбар) зэрэг үгс бүтжээ. Хятад хэлний *tai-* (талбай, тавцан) гэсэн үг нь утгаараа монгол хэлний *tayī-* (тайх), *tāγa-* (таах), *tāγa* (таа), *ta-ba* (тав) хэмээх үгстэй ижил байна. Б.Я.Владимирцов “Эхний тохиолдолд эхний эгшигт өргөлт оногдвол хоёр дахь эгшиг нь уйтан “*i, ī*” эгшгийн өмнөх “*γ/g*” гийгүүлэгч нь “*y*” болон хувирч, улмаар монгол хэлнүүдэд, тухайлбал, халхын аялгуунд хос эгшиг бий болжээ. Нөгөө тохиолдолд хоёр дахь эгшигт өргөлт оногдох ба эдгээр “*a~e, u~ü*” эгшгүүдийн аль нэг нь монгол хэл аялгуунуудад *V+w~y+V>V+y+V* гэсэн нийлэмжээс урт эгшиг үүсэх нөхцөл бүрддэг байна. Уул үгсийн авианд гарсан хувьсал нь утгыг өөрчилж эхэлдэг.” (Б.Я.Владимирцов, 1929) гэж урт хос эгшиг буюу нэвчмэл бүтээвэр нэгэн зэрэг бий болсон хууль зүйг туйлын оновчтой тайлбарласан билээ. Ийнхүү “онцлон ялгах” утгатай. сугардаг “*γ/g*” гийгүүлэгчийн арын эгшигт өргөлт оногдвол өмнөх “*γ/g*” гийгүүлэгч нь гээгдэж, улмаар өргөлтөт эгшиг уртсаж, урт эгшиг болох ба сугардаг гийгүүлэгчийн өмнөх эгшигт өргөлт оногдвол “*γ/g*” гийгүүлэгчийн арын эгшиг нь “*i*” эгшигтэй сэлгэж “*γ/g*”-ээс үүдэлтэй “*y*” гийгүүлэгч гээгдэн хос эгшиг үүсжээ. Жишээ нь: *da-γā-* (даах), *da-yī-* (дайх), *to-γū-* (тоох), *še-gē-* (цэгээ, цэгээн), *šeyi-* (цийх), *se-gē-r* (сээр), *se-yi-* (сийх), *no-ū-ga-* (ноорох), *no-yi-r* (нойр) /М.Базаррагчаа. 2005. 166-216-р тал/ гэх мэтээр харьцуулж болох ба Б.Я.Владимирцов сугардаг “*γ/g*” гийгүүлэгч нь “*b*”-тэй сэлгэдэг болохыг *jaγūra* (зуур) ~ *jabila-*, *jāyila-* (зайлах)~ *jabsar* (завсар), *šayān* (цагаан) ~ *šabi* (цавь) ~ *šayī-* (цайх), *qoyar* (хоёр) ~ **qobar*, *qobusun* (ховс- хоёр настай гахай), *qoyimustai* (хоймстай - хоёр настай) ~ **qobi* ~ *qoyi* (хой - хоёр), *šegēn* (цэгээ, цэгээн) ~ *šeber* (цэвэр), *šegēr* (цээр), *šeyi-* (цийх), *qayuršay* (хуурцаг) ~ **qaburšay*, *qayiršay* (хайрцаг) зэргээр харьцуулсан байна. Эртний монгол хэлнээ *q/k* нь *s/š-* тэй сэлгэдэг байсан тул *qayir*(хайр) нь *sayir* (сайр), *qayirγa* (хайрга) нь *sayirγa* (сайрга дайрга), *kūire-* (хүйрэх) нь *sūyire-* (сүйрэх), *kūi* (хүй) нь *sūi* (сүй тавих) гэж сэлгэж “бутрах, задрах, хэсэг хэсэг болох, холбох” гэсэн утгат үгс бүтжээ. Үгийн дунд орсон “-*yī*” болон сэлгэсэн “ялгах, бага” утга бүхий “*γ/g*” нь “томрох” гэсэн утгатай *q/k-* тэй сэлгэх боловч “бөөгнөрөх” гэсэн утгатай “*b*”-тэй сэлгэж, *sūyī-* нь *sūbe*, *qayī* нь *qabira* зэрэг үгс салаалж болно. Эртний монгол хэлнээ урт, хос эгшиг бий болох нь зөвхөн -*γa* үе-утгалбар, түүний сэлгэсэн хувилбар -*yī* үе-утгалбартай холбогдохоос гадна Б.Я.Владимирцовын үзсэн шиг “*di~dī*”-ээс сэлгэсэн “*jī*” нь улмаар -*yī* бүтэц (үе-утгалбар)-ээс үүсэх боломжтой ажээ. Жишээ нь түрэг хэлний “тавих, зоох. босгох” гэсэн утга бүхий “*γod*”, (киргиз хэлнээ “*коу*”) хэмээх үт нь монгол хэлнээ *qojī-*, **qodī-* (хоцрох, хождох, оройтох, удаашрах, түдэх, хойшлуулах, орхих, хаях) болж “*jī*” үе-утгалбар нь “*yī*” болж *qoyilγa* (хойлго) хэмээх үг бий болсон ажээ. (Б.Я.Владимирцов 1929). Үүнээс “хойш, хойд, хойч, хойно, хоймор” хэмээх үг үүссэн нь хожил хожим, хожих, хожигдох, хонжих зэрэгтэй гарал нэг ажээ. Тэгвэл монгол хэлнээ урт, хос эгшиг буюу нэвчмэл бүтээвэр үүсэх нь “*di~jī~yī*” гэсэн сэлгэцтэй холбоотой ажээ. Энэчлэн *qayīci* (хайч) хэмээх үг нь *qadu-* (өвс хадах), *kidu-* (хядах)-аас үүсэлтэй *qaja-* (хазах), *qaji-* (хажих), улмаар “*jī*” нь дээрхийн адил “-*yī*” болон сэлгэж, *qayīci* (хайч) гэж үүссэн боловч Б.Я.Владимирцов түрэг, ком, шор,

койбал), якут хэлний *qapti, kipti (хайч), монгол хэлний qabči (хавч), *qabtiti хэмээх үгээс үүссэн гэж үзсэн байна. Үүнээс бодвол, энэ үг монгол хэлний qaba- (дээл хавах), qabsu- (хавсах)-тай гарал нэг болно. Эртний түрэг хэлнээ qod- гэдэг нь тавих, үлдээх, хаях, “qodi” гэдэг нь доор” гэсэн утгатай (В. М. Надеяев 1969) бөгөөд үүний “di” нь “ti”- тэй сэлгэснээс монгол хэлнээ qotūyi- (хотойх), kötüyi- (хөтийх), qatayī- (хатайх), keteyi- (хэтийх) зэрэг дүрслэх үг үүссэн нь уг юм доошлох” гэсэн утга илтгэж, qota (хот), qotu (бууны хот) хэмээх үг үүсжээ. Энэхүү “ti” нь “či” болж, qoči- (хоцрох) хэмээх үг бий болсон ажээ. Харин “qoyi” гэх нь алив үйлд хоцорч, хүч хонжих буюу хожих” гэсэн утга бүхий дээрх үгс салбарласан ажээ. Qoūlāi (хоолой), qoūla (хоол), qoūrundu (хооронд), qoūsun (хоосон) ~ qoyar (хоёр) naūd- (наадах) ~ nauida- (найдах) čayān (цагаан) ~ čayī- (цайх) baū- буух) ~ bāyi- (байх) daūari- (дайрах) ~ dayisun (дайсан) taūa- (таах) ~ tayi- (тайх) ta/uūl- (туулах) ~ tūyla- (туйлах) negē- (нээх) ~ neyi- (нийх) noūra- (ноорох) ~ noyir (нойр) jāūa- (эрүү заах) ~ jāyi (зайг хэмжих) jēgū(ū) (зүү) ~ jūyi- (зүйх) jāū- (зуух) ~ jāyi (зай завсар) aūjīm (уужим) ~ aūjīm (аажим), āyīam (айзам) aūari- (аарах), āyira- (айрах) degēre (дээр) ~ deyle- (дийлэх) tegūn (түүн шиг) ~ teyin (тийн) qayurčay (хуурцаг) ~ qayirčay (хайрцаг) gegē (гэгээ) ~ geui- (гийх) гэх мэтээр авиа зүйн хувьд эгшиг хоёр эгшигийн дундах гийгүүлэгч нэмэлт өргөлтөөс болж гээгдсэн бол, бүтээвэр зүйн хувьд “ya -yi” үе утгалбар сэлгэж нэвчмэл бүтээвэр үүсгэжээ.

Авиа-оруулбар ng, m, b, ya зэргийн тухайд, хос үе-утгалбарын завсар гийгүүлэгч авиабар шурган орж, үг бүтээх нь эртний монгол хэлнээ тохиолддог. Жишээ нь: se-de-yi- (сэдийх), saqu-yi- (сахайх) зэргийн тэргүүн ба дэд үе-утгалбарын завсар “n, ng” гэсэн гийгүүлэгч-утгалбар шурган орж sendeyi- (сэндийх), sanquyi- (санхайх), sengkere- (сэнхрэх) зэрэг үг бүтжээ. Жишээ нэмэн дурдвал: si(ng)ge- (шигэх-шингэх), jō(ng)gē (зөөх-зөнгөх), ara(ng)ya (араа-аранга), sol(b)i- (солих-солбих), sele/i- (сэлэх) → selbi- (сэлбэх) čirayī- (чарайх) → čirmayī- (чармайх) qumi- (хумих) → qumbi- (хумбих), qamar (хамар) → qamar, (хамар), → qambar (хамар), qomuī- (хомойх), qom(b)uī- (хомбойх), toūri- (тойрох) → to(ng) yur/a- (тонгорох), taūara- (таарах) → ta(ng)ya- (тангарах), tangara- (тангараг), tuqa (тух) → tu(ng)qa- (тунхах хуучныг шинэтгэн тараах, тунгаах, тухтай ойлгуулах), torūyi- (торойх) → tor(m)uī- (тормойх), sereyi- (сэрийх) → ser(m) eyi- (сэрмийх), soruyi- (соройх) → sor(m)uī- (сормойх), čab čayān (цав цагаан), sib sine (шив шинэ), qob qoūun (хов хоосон), sab sayia (сав сая) гэх зэрэг юм. Ub ulayān (ув улаан) гэхэд орсон “b” оруулбар (инфикс) нь адилтгах утга бүхий betür metür (бэтэр, мэтэр), metü (bel tūsikü) хэмээх бүтээвэр үгийн эхний “b~m” гийгүүлэгч утгалбар нь уул үгийн эхний үе-утгалбарыг давтан, завсар нь шургаж, харьцуулан адилтгаж эрчимжсэн утгыг илтгэнэ. Жишээ нь: qab qara (хав хар), bib bitegü (бив битүү) гэх мэт. Хэрэв “b” нь “n, g”-тэй сэлгэж bing bitegü (бин битүү) гэсэн хувилбар оруулбар бий болдог. Түүнээс гадна энэхүү оруулбар “m” оруулбар aduū maduū (адуу мадуу), kümün mümün (хүн мүн) гэх мэгээр үгийн эхний гийгүүлэгчтэй, эсвэл түүний хувилбартай сэлгэж “хам олон, бас бус, дагалдах” гэсэн уггыг илтгэнэ. Мөн үүнтэй нэгэн адилаар jerge (зэрэг),

selte (сэлт) хэмээх үгсийн эхний “j, s” зэрэг гийгүүлэгч mal zal (мал зал), ger mer (гэр мэр), mangγus sangγus (мангас сангас) зэрэг хоршоо үг бүтээнэ. Ийнхүү “мэт, сэлт, зэрэг” хэмээх үгсийн эхний гийгүүлэгч утгалбар нь тухайн гол үгээ дагалдан дуурайх үгсийг бүтээх боловч тэлгээр нь бие даан хэрэглэгддэггүй “хам олон” ба “эс таашаасан утга» илтгэх туслах үг юм. Мөн “su-n” дагаврын өмнө орсон “-r/a~ -l/a” үе-утгалбар сугарах нь олонтоо байдаг нь оруулбар бүтээврийн эсрэг үзэгдэл аж. Жишээ нь: küyire- (хүйрэх)-ээс küyiresü (хүйс), kölüre- (хөлрөх)-өөс kölüsü (хөлс), тоyūra- (тоорох, тоосрох)-оос тоyūsu (тоос) гэх зэрэг үг бүтжээ.

Авиа- утгварын тухайд, “metü (мэт)>be-l tüsi- (бэл түших), jerge (зэрэг), selte (сэлт), dayūn (дуу дуурайх) зэрэг үгсийн эхний “m, j, s, d” гийгүүлэгч нь адилтгах, зэрэгцүүлэх, дагалдах, дуурайх” гэсэн утга бүхий утгвар гийгүүлэгч үүсжээ. Жишээ нь: aduyū maduyū (адуу мадуу), mal zal (мал зал), ayıray dayıray (айраг дайраг), olqu dolqu (олох долох), mangnay sangnay (магнаг сагнаг), nam jım (нам зам).

Үе- утгалбар сугарах гэдгийн тухайд, монгол хэлний “-su-n” дагаврын өмнө орсон “-ya...” болон “-ra~la...” үе-утгалбар сугарах нь олонтоо тохиолддог. Qayān (хаан) √ya: qan (хан); уayūma (юм) √ya-ma (ям, юм), уayāki-(яа)- √ya: ya-ki-(яа)- √ya: yaki-(ya), таyāna (таана)√ манж: tana (id.), үyūca (ууц) √yu: түрэг: utsa, манж: utsa; silügürkei (шүүрхий мах) √gü: sürkei (шүүрхий); “Онцлон ялгах” утгатай “-ya-“ үе- утгалбар нь утга ялгах үүрэггүй болбол гээгдэх ба гээгдсэнээр “qayān, qan” гэх мэтээр “их бага“-ын утга ялгах нь ч буй. Ćirai (царай), Ćirayı- (чарайх), Ćirmayı- (чармайх), Ćirama (чармай нүцгэн), Ćirama- (чармах) зэрэг үгс нь “өргөх, чирэх зэрэгт чармайн зүтгэж, нүүр царай улайх, судас шөрмөс гүрдийх” гэсэн үйлийн дүрслэлээс үүсжээ. Иймд “царайд улаан туяа татах, нүүр царай, өнгө зүс” гэсэн утга бий болж, нэр бүтээх “-su-n” дагаврын өмнө орсон “-ra...” үе- утгалбар гээгдэж “ĉi(ra)sun” хэмээх хэлбэрээс “ĉisun” (цус) хэмээх үг бүтэх ба “ĉi” нь “ki~si”-тэй сэлгэх тул энэ үг нь “kirayā” (хяраа – үүр тэмдгэрэх үе, нар мандахын өмнө тэнгэрийн хаяа улаанаар туяарах), sira (шар өнгө), sira- (шарах - шар өнгөтэй болох) зэрэгтэй нэг гаралтай болно. Энэ мэтээр, toliyi (толийх)-оос tolisun → tosun (тос) nilayi- (нялайх)-аас nilasin → nisun (нус) nilbayı (нялбайх) -аас nilba/urasun → nilbusu (нулимс) sigüre- (шүүрэх) –ээс sigüre- sün → sigüsü (шүүс) → noūra- (ноорох)-оос nourasun → noūsu (ноос) тоyuray (tobraγ) -оос тоyūrasun→тоyūsu (тоос) jirāyi- (жарайх) - аас yarusun → yasun (яс) dūrisün, dūrsün (дүрс)-ээс jirüsün → jisün (зүс) si(ge)reng (шээрэн)-ээс sigeresün → sigesü (шээс) elere- (элрэх) -ээс eleresün → elesü (элс) küyire- (хүйрэх)-ээс küyiresün → küyi(l)-sü (хүйс, хүйлс) kimul- (хямлах)-аас kimulsun → kimusu (хумс) ĉarayı- (царайх, царцах)-аас ĉarasun → ĉasu (цас) ĉayāra- (цагаарах) – аас ĉarasun → ĉayāsu (цаас) kölüre- (хөлрөх)-өөс kölüresün →kölüsü (хөлс) nabtara- (навтрах)-аас nabtār/asun → nabtasu (навтас) gürbeyı- (гүрвийх)-ээс gürbelsün → gürbesü (гүрвэс) зэрэг үгс бүтжээ.

Ийнхүү профессор М.Базаррагчаагийн боловсруулсан эртний монгол хэлний үг бүтэх ёс гэх онол нь монгол хэлний гарал судлал, түүхэн бүтээвэр судлалын цоо шинэ үзэл арга зүй болж буй билээ.

Ташрамд дурдахад, профессор М.Базаррагчаагийн монгол хэлний гарал судлал түүхэн бүтээвэр судлалын бүтээлүүд нь зөвхөн монгол хэл төдийгүй, алтай хэлнүүдийн төрөл гарал нэгтэй олон үгийг тодруулсан байдгаараа, бас судлах арга зүйн хувьд ч алтай судлалын чухал судалгаа болж байдаг.

Профессор М.Базаррагчаа багшийн монгол хэлний түүхэн гарал судлал, түүхэн бүтээвэр судлалын бүтээлүүдийг судлаачид “эртний монгол хэлний бүтээврийн бүтэц бүрэлдэхүүн тэдгээрийн гарлыг тодорхойлсон цуврал бүтээл туурвисан нь монгол хэлний судлалын нэг салбарын үүд хаалгыг цэлийтэл нээлээ”, “монгол хэлний бүтэц нь өөрөө өөрийгөө тайлах түлхүүртэй юм гэдгийг баталж өглөө”, “монгол хэлний түүхэн бүтээвэр судлал буюу гарал судлын тулгуур бүтээлийн нэг” (Болд 1995: 107-117) “ховор бүтээл” “монголын хэл шинжлэлийн ухааны атар газарт ургуулсан цорын ганц саглагар мод” (Түдэв 1996: 129) гэх зэргээр зүй ёсоор үнэлжээ.

Ном зүй

- Базаррагчаа М. (1987). Монгол хэлний авиа сэлгэх ёс. Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1992). Монгол үгийн гарлыг мөшгих нь. I-II. Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1994). Монгол үгийн гарлыг мөшгих нь III-V, Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1996). Ажнай. Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1996). Монгол хэлний “-су-н” дагавар ба “-су-н” дагаварт үгийн гарал I, Улаанбаатар.
- Базаррагчаа М. (2005). Эртний монгол хэлний үгийн бүтэц, түүний зарим онцлог. Улаанбаатар.
- Базаррагчаа М. (2020). Монгол үгийн гарлыг мөшгөх нь. VII, Улаанбаатар.
- Базаррагчаа М. (1997). Структура слова и её некоторые особенности в древнемонгольском языке. Автореферат диссертации на соискание учёной степени доктора филологических наук Улаанбаатар
- Болд Л. (1995). Түүхэн бүтээвэр судлалын нэг шинэ бүтээлийн тухай (шүүмж) МУҮИС Монгол судлалыг хүрээлэн, эрдэм шинжилгээний бичиг Боть 6 (114) дэвтэр XV, Улаанбаатар.
- Владимирцов Б. Я. (1929). *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия* Ленинград.
- Ринчен Б. (1966). Монгол бичгийн хэлний зүй гутгаар дэвтэр хэлбэр судлал Улаанбаатар.
- Түдэв Л. (1996). Үгсийн нууц уурхай Улаанбаатар.
- Цэцэнцогт. (1988) Монгол үгсийн язгуурын толь. Жанг Жияа Key.
- Poppe N. (1960) *Vergleichende Grammatik der altaischen Sprachen Teil I Vergleichende Lautlehre* Wiesbaden. Porta Linguarum Orientalium Neue Serie 4.
- Ramstedt G. J. (1935). *Kalmückisches Wörterbuch*. Helsinki.
- Ramstedt G. J. (1949). *Studies in Korean Etymology*. Helsinki. Mémoires de la Société Finno-Ougrienne 95.
- Ramstedt G. J. (1952). *Einführung in die Altaische Sprachwissenschaft II. Formenlehre*. Helsinki. Mémoires de la Société Finno-Ougrienne 104 (II).